



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2024 оны 03 сарын 05 өдөр

Дугаар А/112

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, 8.1.14 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой үүссэн тохиолдлыг бүртгэх, мэдээлэх, хариу арга хэмжээ авах журам”- ыг нэгдүгээр, “Тохиолдол, эрсдэлийн мэдээллийн нэгдсэн санг ашиглах журам”-ыг хоёрдугаар, “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөө боловсруулах, үнэлэх, тайлагнах заавар”-ыг гуравдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.
2. Энэхүү тушаалыг хэрэгжүүлэхэд мэргэжлийн арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газар (А.Өнөржаргал)-т, Мэдээллийн сангийн тасралтгүй үйл ажиллагааг ханган ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв (Б.Нарантуяа) -д тус тус даалгасугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналтын газар (С.Сүнчин)-т даалгасугай.
4. Тушаалд өөрчлөлт оруулсантай холбоотой “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах зарим арга хэмжээний тухай” Эрүүл мэндийн сайдын 2019 оны 566 дугаар тушаалын нэгдүгээр, гуравдугаар хавсралтыг тус тус хүчингүйд тооцсугай.

САЙД  С.ЧИНЗОРИГ



141240439

Эрүүл мэндийн сайдын 2024 оны ...
сарын ... өдрийн ... дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ ХОЛБООТОЙ ҮҮССЭН ТОХИОЛДЛЫГ БҮРТГЭХ, МЭДЭЭЛЭХ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотойгоор үйлчлүүлэгчийн болон үйлчилгээ үзүүлэгчийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх тохиолдлуудад (цаашид тохиолдол гэх) дүн шинжилгээ хийх, шалтгааныг тогтоох, мэдээлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, хариу арга хэмжээ авахтай холбоотой асуудлыг энэ журмаар зохицуулна.

1.2. Энэхүү журмын зорилго нь тусламж, үйлчилгээтэй холбоотой үүссэн үйлчлүүлэгчийн болон үйлчилгээ үзүүлэгчийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх тохиолдлуудыг бүртгэх, мэдээлэх, хариу арга хэмжээ авах, давтан гарахаас сэргийлэх, эрүүл мэндийн байгууллагууд харилцан суралцах замаар тусламж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулахад оршино.

1.3. Тохиолдолд дүн шинжилгээ хийн хариу арга хэмжээ авахдаа байгууллагын үйл ажиллагаанаас үүдэлтэй шалтгааныг нэн тэргүүнд илрүүлэн үндсэн шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлсийг тогтоох бөгөөд тохиолдлын мэдээлэлд дүн шинжилгээ хийлгүйгээр аливаа дүгнэлт гаргахгүй.

1.4. Энэ журмаар зохицуулагдаж байгаа үйлчлүүлэгчийн болон үйлчилгээ үзүүлэгчийн эрүүл мэнд, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх тохиолдлуудыг дараах байдлаар ойлгоно. Үүнд:

- 1.4.1. Алдах дөхсөн тохиолдол – Үйлчлүүлэгчид хохирол учруулж болзошгүй байсан ч таслан зогсоосон үйлдлийг;
- 1.4.2. Тохиолдол- Үйлчлүүлэгчийн эрүүл мэнд, аюулгүй байдалд нөлөөлсөн, нөлөөлж болзошгүй байдлыг;
- 1.4.3. Таагүй тохиолдол - Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх явцад үйлчлүүлэгчид сөрөг үр дагавар үзүүлсэн нөхцөл байдлыг;
- 1.4.4. Ноцтой тохиолдол - Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх явцад үйлчлүүлэгч ноцтойгоор хохирох, эсвэл амь насаа алдахад хүргэсэн үр дагаврыг;
- 1.4.5. Эмнэлгийн алдаа – Төлөвлөсөн үйл ажиллагаа хэрэгжихгүй байх эсвэл буруу төлөвлөн хэрэгжүүлсэн, зөв төлөвлөсөн үйл ажиллагааг буруу хэрэгжүүлсэн үйлдлийг;

1.5. Үйлчлүүлэгчийн эрүүл мэнд, аюулгүй аюулгүй байдал алдагдсан тохиолдлуудын шийдвэрлэх зорилтуудыг дараах байдлаар тодорхойлно. Үүнд:

- 1.5.1. зөв танин тодруулах
- 1.5.2. үр дүнтэй харилцааг сайжруулах
- 1.5.3. өндөр эрсдэлт эмийн аюулгүй байдлыг хангах
- 1.5.4. мэс заслын аюулгүй байдлыг хангах
- 1.5.5. эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдварын эрсдэлийг бууруулах

- 1.5.6. тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангах
 - 1.5.7. уналтаас үүдэлтэй үйлчлүүлэгч хохирох эрсдэлийг бууруулах
 - 1.5.8. цусны аюулгүй байдлыг хангах
- 1.6. Үйлчлүүлэгчийн эрүүл мэнд, аюулгүй байдал алдагдсан тохиолдлуудын эмнэл зүйн шалтгааныг дараах байдлаар тодорхойлно. Үүнд:
- 1.6.1. зөв танин тодруулах үйл явц алдагдсантай холбоотой
 - 1.6.2. эмнэлзүйн үр дүнтэй харилцаа алдагдсантай холбоотой
 - 1.6.3. өндөр эрсдэлт эмийн аюулгүй байдал алдагдсантай холбоотой
 - 1.6.4. мэс заслын аюулгүй байдал алдагдсантай холбоотой
 - 1.6.5. халдвараас сэргийлэх хяналт алдагдсантай холбоотой
 - 1.6.6. тээвэрлэлтийн аюулгүй байдал алдагдсантай холбоотой
 - 1.6.7. эмнэлгийн орчинд унасан
 - 1.6.8. цусны аюулгүй байдал алдагдсантай холбоотой
 - 1.6.9. бусад шалтгаан
- 1.7. Үйлчлүүлэгчийн эрүүл мэнд, аюулгүй байдал алдагдсан тохиолдлуудын эмнэл зүйн бус шалтгааныг дараах байдлаар тодорхойлно. Үүнд:
- 1.7.1. эмнэлгийн тоног төхөөрөмж, эм, хэрэгсэлтэй холбоотой
 - 1.7.2. үйлчлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгч хүчирхийлэлтэй холбоотой
 - 1.7.3. санхүү, төлбөр тооцоотой холбоотой
 - 1.7.4. эмнэлгийн мэдээллийн системтэй холбоотой
 - 1.7.5. барилга, байгууламжтай холбоотой
 - 1.7.6. зохион байгуулалт, менежменттэй холбоотой
 - 1.7.7. харилцаа хандлагатай холбоотой
 - 1.7.8. бусад шалтгаан
- 1.8. Энэхүү журмын 1.4.-т заасан үйлчлүүлэгчийн эрүүл мэнд, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлсийг дараах байдлаар тодорхойлно. Үүнд:
- 1.8.1. үйлчлүүлэгчийн хүчин зүйл
 - 1.8.2. ажилтны хүчин зүйл
 - 1.8.3. ажлын болон үйлчилгээний орчны хүчин зүйл
 - 1.8.4. багийн хүчин зүйл
 - 1.8.5. баримт бичиг, цахим бүртгэлийн хүчин зүйл
 - 1.8.6. технологийн хүчин зүйл
 - 1.8.7. бүтэц, зохион байгуулалтын хүчин зүйл
- 1.9. Байгууллага бүр өөрийн тусламж, үйлчилгээний өвөрмөц онцлогтой холбоотой энэхүү журмын 1.4-т заасан тохиолдлуудад хамаарах жагсаалтыг гарган батлуулна.

Хоёр. Тохиолдлыг бүртгэх, мэдээлэх ерөнхий зарчим

- 2.1. Эрүүл мэндийн байгууллагын ажилтан бүр тохиолдлыг шуурхай мэдээлэх үүрэгтэй.
- 2.2. Мэдээлэлд дүн шинжилгээ хийлгүйгээр эрүүл мэндийн ажилтны тохиолдолтой холбоотой ажлын гүйцэтгэлийг үнэлэхгүй.

- 2.3. Тохиолдлыг мэдээлэх, бүртгэх, үндсэн шалтгааны дүн шинжилгээ хийх, эргэн мэдээлэх бүхий л үйл ажиллагааг баримтжуулсан байна.
- 2.4. Тохиолдлын үндсэн шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлийг энэхүү журмын 1.5, 1.6, 1.7, 1.8-д заасны дагуу тодорхойлж, тохиолдлын үр дагаврын ангилал, мэдээлэх түвшний (Хүснэгт 1) дагуу мэдээлнэ.
- 2.5. Тохиолдлын нэгдсэн сангийн ажиллах журмыг баримтлан эрүүл мэндийн байгууллагын Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын (цаашид ЭМТҮЧАБА гэх) алба/багийн ажилтан мэдээлэл илгээнэ.
- 2.6. Тухайн эрүүл мэндийн байгууллагад олгогдсон эрхийн дагуу мэдээллийн сангаас эрүүл мэндийн ажилтан бүр нэвтэрч мэдээлэл авч болно.
- 2.7. Тохиолдлын нэгдсэн санд бүртгэгдсэн тохиолдлууд нь хэрэглэгчдэд орон нутаг, эрүүл мэндийн байгууллагын нэр, эрүүл мэндийн ажилтан, үйлчлүүлэгчийн нэр хаяггүйгээр гарсан тохиолдол, шийдвэрлэсэн арга зам хэлбэрээр харагдах бөгөөд зөвхөн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах, харилцан суралцах, туршлага хуваалцах зорилгоор хэрэглэгдэнэ.
- 2.8. Тохиолдлыг илрүүлэн мэдээлсэн ажилтныг зэмлэн буруутгах бус эерэг, бүтээлч арга замаар асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэн тусламж, үйлчилгээний чанар сайжруулах үйл ажиллагаанд оролцсонд тооцно.
- 2.9. Эрүүл мэндийн байгууллага нь тохиолдлын шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлийг арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх бөгөөд ЭМТҮЧАБ-ын алба/баг нь тохиолдлыг дахин давтан гаргахгүй байх, дараагийн гарч болзошгүй эрсдэлд үнэлгээ хийн, чанар сайжруулах арга хэмжээг зохион байгуулна.

Гурав. Эрүүл мэндийн байгууллагад тохиолдлыг ангилах, бүртгэх, мэдээлэх

- 3.1. Тохиолдлыг анх харсан, оролцсон, илрүүлсэн ажилтан Тохиолдол, эрсдэлийн мэдээллийн нэгдсэн сан <https://eburtgel.moh.gov.mn/>-д бүртгэж мэдээлнэ. Эрүүл мэндийн байгууллага, эмнэлэгт хэрэглэгддэг мэдээлэл харилцаа холбооны хэрэгсэл ашиглан байгууллагын дотоод сан үүсгэж болно.
- 3.2. Мэдээлэгдсэн тохиолдлыг ЭМТҮЧАБ-ын алба/баг ангилан цаашид авах арга хэмжээний чиглэлийг гаргана.
- 3.3. Энэ журмын 1.4.1-д заасан нөхцөл байдал үүссэн бол “Алдах дөхсөн тохиолдол” 1А гэж бүртгэн тасаг/нэгжийн түвшинд хэлэлцэн авсан арга хэмжээг ЭМТҮЧАБ-ын алба /баг-т мэдээлнэ.
- 3.4. Энэ журмын 1.4.2-т заасан нөхцөл байдал үүссэн бол “Тохиолдол” 1Б гэж бүртгэн, тасаг/нэгжийн түвшинд үндсэн шалтгааныг тодорхойлон хэлэлцэж, авсан арга хэмжээг ЭМТҮЧАБ-ын алба/багт мэдээлнэ.
- 3.5. Энэ журмын 1.4.3-т заасан “Таагүй тохиолдол”-д 2 гэж бүртгэн, ЭМТҮЧАБ-ын алба/багийн түвшинд үндсэн шалтгааныг тодорхойлон хэлэлцэж, байгууллагын удирдлагад мэдээлнэ.
- 3.6. Энэ журмын 1.4.4-т заасан “Ноцтой тохиолдол”-д 3 гэж бүртгэн ЭМТҮЧАБ-ын алба/багийн түвшинд үндсэн шалтгааныг тодорхойлон хэлэлцэж, байгууллагын удирдлагад мэдэгдэн Тохиолдол, эрсдэлийн мэдээллийн нэгдсэн сан <https://eburtgel.moh.gov.mn/>-д мэдээлэх бөгөөд Эрүүл мэндийн хөгжлийн төв нь Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газарт шууд мэдээлнэ.

3.7. Энэ журмын 1.4.5-д заасан “Эмнэлгийн алдаа” гэж тогтоогдсон бол холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлэнэ.

3.8. 1А, 1Б ангилалд хамаарах тохиолдлыг тасаг/нэгжид сургалт зохион байгуулах, тохиолдол гаргах шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлийг арилгах, эрсдэлээс сэргийлэх зэрэг арга хэмжээ авна.

3.9. Тохиолдол нь 2, 3 ангилалд хамаарагдаж байвал ЭМТҮЧАБ-ын алба/баг нь дүн шинжилгээний багийг зохион байгуулна.

3.9.1. Дүн шинжилгээний багт эмнэлзүйн тухайн чиглэлээр мэргэшсэн болон ашиг сонирхлын зөрчилгүй, хараат бус шийдвэр гаргах чадвартай мэргэжилтнүүдийг сонгох ба тогтолцоо, үйл явц, үйлчилгээг сайжруулахад чиглэсэн зөвлөмж, дүгнэлт гаргана.

3.9.2. ЭМТҮЧАБ-ын алба/баг нь хариу арга хэмжээний төлөвлөгөөг дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн боловсруулж хэрэгжилтийг ханган тайлагнана.

3.10. Шаардлагатай гэж үзвэл хөндлөнгийн хяналт хийх дүн шинжилгээний багийг Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн газар томилон ажиллуулж болно.

3.11. Нийгмийн сүлжээгээр түгээгдсэн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой сөрөг мэдээллийг ЭМТҮЧАБ-ын алба/баг нь тохиолдол гэж бүртгэх бөгөөд дүн шинжилгээ хийж хариу арга хэмжээ авч шаардлагатай тохиолдолд Эрүүл мэндийн яам болон олон нийтэд тайлбар хүргэнэ.

3.12. Энэхүү журмын хоёрдугаар хавсралтад заасан “Тохиолдол, эрсдэлийн мэдээллийн нэгдсэн сан”-д ажиллах журмын дагуу тухайн эрүүл мэндийн байгууллагаас эрх олгогдсон ажилтан тухайн тохиолдлын шийдвэрлэлтийн байдлыг илгээнэ.

Хүснэгт 1. Тохиолдлын үр дагаврын ангилал, мэдээлэх түвшин

Ангилал	Тохиолдлын тодорхойлолт	Зэрэглэл	Тохиолдлын үр дагаврын ангилал	Авах арга хэмжээ, мэдээлэл түвшин
Алдах дөхсөн тохиолдол	Хор хөнөөлд хүргэж болзошгүй байсан ч таслан зогсоосон үйлдэл.	1А	Ажилтан, үйлчлүүлэгч, зочны биемахбодид гэмтэл учруулаагүй,	Тасаг/нэгжийн түвшинд хэлэлцэн үндсэн шалтгааныг тодорхойлж авсан хариу арга
Тохиолдол	Анхаарал татсан нөхцөл байдал үүсэх	1Б	аюулгүй байдал, байгууллагын нэр хүндэд нөлөөлөөгүй	хэмжээг ЭМТҮЧАБ-ын алба/багт мэдээлнэ.

Таагүй тохиолдол	Эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой үйлчлүүлэгчид сөрөг үр дагавар үзүүлсэн нөхцөл байдал үүсэх	2	Ажилтан, үйлчлүүлэгч, зочны биемахбодид түр зуурын өөрчлөлт, гэмтэлийн хэмжээ бага	ЭМТҮЧАБ-ын алба/багт үндсэн шалтгааныг тодорхойлж авсан хариу арга хэмжээг байгууллагын удирдлагад мэдээлнэ.
Ноцтой тохиолдол	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх явцад өвчтөнд бие махбод болон сэтгэцийн эрүүл мэндэд ноцтой гэмтэл учруулах, эсвэл амь насаа алдахад хүргэсэн ямар нэг урьдчилан таамаглаагүй нөхцөл байдал үүсэх	3	Ажилтан, үйлчлүүлэгч, зочны биемахбодид түр зуурын өөрчлөлт үзүүлсэн, хор уршиг учруулаагүй боловч гомдоосон, байгууллагын нэр хүндэд нөлөөлсөн	ЭМХТ-ийн “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой “Тохиолдол, эрсдэлийн мэдээллийн нэгдсэн сан” /eburtgel.moh.gov.mn/-д -д нэн даруй мэдээлнэ. ЭМТҮЧАБ-ын алба/баг, дүн шинжилгээний баг хэлэлцэн үндсэн шалтгааныг тодорхойлж хариу арга хэмжээ авна.
Эмнэлгийн алдаа	Төлөвлөсөн үйл ажиллагаа хэрэгжихгүй байх эсвэл буруу төлөвлөн хэрэгжүүлсэн, зөв төлөвлөсөн үйл ажиллагааг буруу хэрэгжүүлсэн үйлдэл			Холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлэнэ.

Эрүүл мэндийн сайдын 2024 оны ...
сарын ... өдрийн ... дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

“ТОХИОЛДОЛ, ЭРСДЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН”-Г АШИГЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой үйлчлүүлэгч болон үйлчилгээ үзүүлэгчийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх тохиолдол, эрсдэлийг бүртгэн Тохиолдол, эрсдэлийн мэдээллийн нэгдсэн сан <https://www.eburtgel.moh.gov.mn/>-д мэдээлэх, мэдээллийн нэгдсэн өгөгдлийн санг бий болгохтой холбоотой асуудлыг зохицуулна.
- 1.2. Эрүүл мэндийн хөгжлийн төв нь программ хангамжийн аюулгүй байдал, хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж салбарын хэмжээнд нотолгоо бүхий мэдээллээр хангах, эргэх холбоо тогтоох, эрүүл мэндийн байгууллагуудын харилцан суралцах, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх үүрэгтэй ажиллана.
- 1.3. Эрүүл мэндийн хөгжлийн төв нь Эрүүл мэндийн яамны харьяа байгууллагын тусламж, үйлчилгээтэй холбоотой гарсан тохиолдол, эрсдэлийн мэдээлэлд хяналт тавьж хариу арга хэмжээ авч ажиллана.
- 1.4. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар харьяалах нутаг дэвсгэр дэх эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээтэй холбоотой гарсан тохиолдол, эрсдэлийн мэдээлэлд дүгнэлт хийж, хариу арга хэмжээ авч ажиллана.
- 1.5. Эрүүл мэндийн байгууллагын удирдлага нь ажилтнуудыг зэмлэн буруутгахгүйгээр “Тохиолдол, эрсдэлийн мэдээллийн нэгдсэн сан” <https://www.eburtgel.moh.gov.mn/>-д эрсдэл тохиолдлыг мэдээлэх нөхцөл бүрдүүлсэн байна.
- 1.6. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албаны менежер нь тус программд хандах эрх бүхий албан тушаалтан байх бөгөөд байгууллагын нэвтрэх нэр, нууц дугаарыг эзэмшинэ.
- 1.7. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын эмнэлгийн тусламж, үйлчилгээний хэлтсийн дарга, чанарын асуудал хариуцсан мэргэжилтэн нь тухайн нутаг дэвсгэр дээр гарсан тохиолдол, эрсдэлийн мэдээлэлд дүгнэлт хийж, аюулгүй байдлыг ханган хариу арга хэмжээг авч программд хандах эрх бүхий албан тушаалтан байна.
- 1.8. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлын асуудал хариуцсан нэгжийн ажилтан нь салбарын хэмжээний программд хандах эрх бүхий албан тушаалтан байх бөгөөд программын өдөр тутмын хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангаж ажиллах эрх бүхий албан тушаалтан байна.
- 1.9. Программ хангамжид хэрэглэгдэж буй нэршлийг дор дурдсан утгаар ойлгоно.
 - 1.9.1. Мэдээллийн нэгдсэн сан - Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой үүссэн үйлчлүүлэгч болон үйлчилгээ үзүүлэгчдийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх тохиолдол, эрсдэлийн бүртгэл, тусламж, үйлчилгээнд нэвтрүүлсэн сайн туршлага, ноцтой болон таагүй тохиолдол, эрсдэлийн

сэрэмжлүүлэг, тус программ ашиглаж байгаа нийт хэрэглэгчдийн мэдээллийг багтаасан цахим санг хэлнэ.

1.9.2. Сайн туршлага – Эрүүл мэндийн салбарт тохиолдол, эрсдэлийг бууруулах зорилгоор төлөвлөн хэрэгжүүлсэн хариу арга хэмжээний сайн үр дүн өгсөн үйл ажиллагааг ойлгоно.

Хоёр. Тохиолдол, эрсдэлийн мэдээллийн нэгдсэн санд ажиллах зарчим

2.1. Хэрэглэгчид дараах зарчмыг баримтлан ажиллана. Үүнд:

- 2.1.1. хувь хүний болон байгууллагын нууц хадгалах;
- 2.1.2. хувь хүний мэдээллийг хамгаалах;
- 2.1.3. зэмлэн буруутгахгүй байх;
- 2.1.4. сайн туршлагаа хуваалцах, харилцан суралцах;
- 2.1.5. үнэн зөв мэдээлэх;
- 2.1.6. хүний эрх, эрх чөлөөг зөрчихгүй байх;
- 2.1.7. хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;
- 2.1.8. ялгаварлан гадуурхахгүй байх,

Гурав. Үйл ажиллагаа

3.1. Программыг дуудах, бүртгүүлж нэвтрэх

3.1.1. Ажилтан дурын веб (google.com, Microsoft edge, fox болон бусад) хөтчид <https://eburtgel.moh.gov.mn/login> хаягийг бичиж программыг дуудахад доорх цонх нээгдэнэ

3.1.2. Ажилтан программд бүртгүүлэх - Ажилтан анх удаа хандаж байгаа бол эхлээд “БҮРТГҮҮЛЭХ” товчийг дарж бүртгүүлнэ.

3.1.3. Бүртгүүлэх цонхонд нэвтэрч эрүүл мэндийн ажилтан мэдээллийг үнэн зөв бөглөнө. Нууц үг: нүдэнд 8 тэмдэгтээс дээш тоо, том жижиг үсэг, тусгай тэмдэг хольж оролцуулсан нууц үгийг латин үсгээр бичнэ. Бүх нүдийг зөв бөглөж дуусаад БҮРТГҮҮЛЭХ товчийг дарснаар ажилтны бүртгэл хадгалагдана.

3.1.4. Аль нэг нүдийг дутуу, буруу бөглөсөн бол алдаа гэсэн тэмдэглэл гарна. Бөглөсөн мэдээллийг нягталж дахин “БҮРТГҮҮЛЭХ” товчоо дарж бүртгүүлнэ.

3.1.5. Бүртгэл амжилттай хийгдсэний дараа программ “НЭВТРЭХ” цонх руу шилжинэ.

3.2. Программд ажиллах

3.2.1. Ажилтан нь энэхүү зааврын 3.1-д заасны дагуу программыг дуудан өөрийн нэвтрэх нэр, нууц үгийг оруулан программд нэвтэрнэ.

3.2.2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой тохиолдол, эрсдэлийг бүртгэх ажлын талбар (нүүр хуудас) гарч ирнэ.

3.2.2.1 “АЖИЛТНЫ МЭДЭЭЛЭЛ” товчийг дарж өөрийнхөө мэдээллээ харах, алдаатай оруулсан мэдээллээ засах боломжтой.

3.2.2.2 “НИЙТ ТОХИОЛДОЛ” товчийг дарж өөрийн бүртгэсэн тохиолдлын шийдвэрлэлт, ангилалаар нь ялгаж харах, хайлт хийж болно.

3.2.2.3 “НИЙТ ЭРСДЭЛ” товчийг дарж өөрийн бүртгэсэн эрсдэлийн зэргээр нь ялгаж харах, хайлт хийж болно.

3.2.3 “+ШИНЭЭР ТОХИОЛДОЛ БҮРТГЭХ” хэсэгт дарж шинэ тохиолдол бүртгэнэ.

3.2.4 “+ШИНЭЭР ЭРСДЭЛИЙГ БҮРТГЭХ” товчийг дарж шинэ эрсдэлийг бүртгэнэ.

3.2.5 Нүүр хуудасны доод хэсэгт Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс мэдээлж буй мэдээллүүд харагдана.

3.2.6. Нүүр хуудасны зүүн хэсэгт “ҮНДСЭН ЦЭС” харагдана.

3.2.6. Тохиолдол мэдээлэх

3.2.6.1 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой тохиолдол, эрсдэлийг бүртгэх ажлын талбарын (+ШИНЭЭР ТОХИОЛДЛЫГ БҮРТГЭХ) хэсэгт нэвтэрнэ.

3.2.6.2 Ажилтан (Тохиолдлыг тасаг нэгжид бүртгэх хуудас)-ны тохиолдол гарсан байршил, тасаг (нэгж), гаргасан үйлчлүүлэгчийн нэр, эсвэл хүний нэр, албан тушаал, тохиолдол гарсан огноо, дэлгэрэнгүй мэдээлэл хэсгийг үнэн зөв бөглөн хадгалах товчийг дарснаар тохиолдол бүртгэгдэж хадгалагдана.

3.2.6.3 Хадгалах товчлуурыг дарахад АМЖИЛТТАЙ гэж гарах бөгөөд үүний дараа ОК товчийг дарснаар цонхны баруун дээд буланд дэлгэрэнгүй мэдээллийг файл, зурган хэлбэрээр хадгалах товч гарч ирнэ.

3.2.6.4 ОК товчийг дарахад цонхны баруун дээд буланд дэлгэрэнгүй мэдээллийг файл-1МВ, зураг -15 МВ хэмжээтэйгээр оруулаад хадгалах товчийг дарж хадгална.

3.2.6.4 Ажилтны бүртгэсэн тохиолдол өөрийн байгууллагын ЭМТҮЧАБ-ын албанд шилжсэнээр ажилтны бүртгэгдсэн тохиолдол амжилтай бүртгэгдэн хадгалагдана.

3.2.7 Эрсдэл мэдээлэх

3.2.7.1 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой тохиолдол, эрсдэлийг бүртгэх ажлын талбарын (+Шинээр эрсдэл бүртгэх) хэсэгт нэвтэрнэ.

3.2.7.2 Ажилтан (Эрсдэлийг тасаг нэгжид бүртгэх хуудас)-ны байршил, тохиолдол тасаг (нэгж), эрсдэл гаргасан огноо, эрсдэлийн тухай хэсгийг үнэн зөв бөглөн хадгалах товчийг дарснаар эрсдэл бүртгэгдэж хадгалагдана.

3.2.7.3 Хадгалах товчлуурыг дарахад АМЖИЛТТАЙ гэж гарах бөгөөд үүний дараа ОК товчийг дарснаар цонхны баруун дээд буланд дэлгэрэнгүй мэдээллийг файл, зурган хэлбэрээр хадгалах товч гарч ирнэ.

3.2.7.4 ОК товчийг дархад цонхны баруун дээд буланд дэлгэрэнгүй мэдээллийг файл-1МВ, зураг-15 МВ хэмжээтэйгээр оруулаад хадгалах товчуудыг дарж хадгална.

3.2.8 Программд файл, зураг хавсаргах

3.2.8.1. Ажилтан тохиолдол, эрсдэл бүртгэхдээ түүнтэй холбоотой текст мэдээллийг шивж оруулах болон бэлэн бичсэн файл, зураг хавсаргаж болно. Энэ үйлдэл нь зөвхөн шинээр тохиолдол, эрсдэлийг бүртгэх явцад хийгдэнэ.

3.2.8.3. Файл болон зургийг өөрийн компьютер болон гар утас дээр идэвхжүүлээд ENTER товчийг дарна.

3.2.8.4. Бүртгэсний эцэст ОК товчийг дарахад цонхны баруун дээд буланд дэлгэрэнгүй мэдээллийг файл, зурган хэлбэрээр хадгалах товч гарч ирнэ.

3.2.8.5. Уг товчийг дарж өөрийн файл, үсгэн мэдээлэл, зургийг оруулах боломжтой болно.

Дөрөв. Программд ажиллах байгууллагуудын үйл ажиллагаа

4.1. Ажилтан, тасаг/нэгжийн түвшинд:

- 4.1.1. Хэрэглэгч буюу ажилтан нь өөрийн нэвтрэх нэр, нууц үгийг бусдад алдахаас сэргийлэх үүрэгтэй бөгөөд бусдад шилжүүлэхгүй байх;
- 4.1.2. Хэрэглэгч буюу ажилтан нь Мэдээллийн нэгдсэн санд худал мэдээлэл оруулахгүй байх;
- 4.1.3. Тасаг нэгжийн эрхлэгч нь “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой үүссэн тохиолдлыг бүртгэх, мэдээлэх хариу арга хэмжээ авах журам”-д заасан тасаг, нэгжийн түвшинд шийдвэрлэх тохиолдол, эрсдэлд дүн шинжилгээг хийх, хариу арга хэмжээ авсан талаар тухай бүр ЭМТҮЧАБ-ын алба/баг-т мэдээлэх.

4.2. ЭМТҮЧАБ-ын алба/багийн түвшинд:

- 4.2.1. Ажилтны бүртгэсэн тохиолдол, эрсдэлийн мэдээлэл тухайн байгууллагын ЭМТҮЧАБ-ын албанд шилжсэнээр амжилтай бүртгэгдэн хадгалагдах тул тоног төхөөрөмж, программ хангамжийн байдлыг хангаж ажиллах;
- 4.2.2. Байгууллагынхаа ажилтнуудад программ ашиглалтын талаар сургалт зохион байгуулах мэргэжил арга зүйгээр хангах;
- 4.2.3. “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой үүссэн тохиолдлыг бүртгэх, мэдээлэх хариу арга хэмжээ авах журам”-нд заасан ЭТҮЧАБА-ны түвшинд шийдвэрлэх тохиолдол, эрсдэлд дүн шинжилгээг хийх, хариу арга хэмжээ авсан талаар Эрүүл мэндийн сайдын баталсан “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой үүссэн тохиолдлыг бүртгэх, мэдээлэх, хариу арга хэмжээ авах журам”-ын дагуу мэдээлэх;
- 4.2.4. Өөрийн эрүүл мэндийн байгууллагад бүртгэгдсэн тохиолдолд дүн шинжилгээ хийж хагас жил тутамд, эрсдэлд дүн шинжилгээ хийж улирал тутамд Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн хөгжлийн төвд тайланг хүргүүлэх,

4.3. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын түвшинд:

- 4.3.1. Харьяалах нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг эрүүл мэндийн байгууллагуудын бүртгэгдсэн тохиолдол, эрсдэлд хөндлөнгийн хяналт тавьж тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх;
- 4.3.2. Харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагыг программд хандах эрхийг нээж өгөх, программ ашиглалтын талаар сургалт зохион байгуулах мэргэжил арга зүйгээр хангах;
- 4.3.3. Эрүүл мэндийн байгууллагаас илгээсэн тохиолдол, эрсдэлд дүн шинжилгээг хийх, хариу арга хэмжээ авах;
- 4.3.4. Харьяалах эрүүл мэндийн байгууллагуудын тайлан мэдээг нэгтгэн дүн шинжилгээ хийж Эрүүл мэндийн хөгжлийн төвд тайлагнах;

- 4.3.5. Шаардлагатай тохиолдолд дүн шинжилгээний багт орж ажиллан дүгнэлт, зөвлөмж гаргах,
- 4.4. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн түвшинд:
- 4.4.1. Тус программ хангамжийн ерөнхий зохицуулгын үүргийг гүйцэтгэж программын мэдээллийн баазад өгөгдөл, мэдээллийг нэмэх, хасах, засварлаж, устгах;
- 4.4.2. Программд бүртгэгдсэн тохиолдол, эрсдэлд дүн шинжилгээ хийх, нэгдсэн санд хадгалах, мэдээллийн аюулгүй байдлыг хангаж бусдад дамжуулахгүй байх;
- 4.4.3. Программд холбогдсон эрүүл мэндийн байгууллагууд хоорондын мэдээллийн солилцоог сайн туршлага, сэрэмжлүүлэг болгон нэгдсэн зохицуулалтаар хангах;
- 4.4.4. Программ хангамжийн ашиглалтын талаар сургалт зохион байгуулах, мэргэжил арга зүйгээр хангах;
- 4.4.5. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрыг программд хандах эрхийг нээж өгөх мэргэжил арга зүйгээр хангах;
- 4.4.6. Эрүүл мэндийн байгууллагыг программд бүртгэх, хандах эрхийг үүсгэх мэргэжил арга зүйгээр хангах;
- 4.4.7. Эрүүл мэндийн байгууллагын тасаг, нэгжийн бүлэг үүсгэх, мэргэжил, ажлын байрны нэршлийг нэмэх, тохиолдол, эрсдэлийн төрөл, зэргээр тохируулга хийх;
- 4.4.8. Эрх зүйн баримт бичиг, мэдээ мэдээлэл, сэрэмжлүүлгийг программ хэрэглэгчдэд түгээх;
- 4.4.9. Хэрэглэгчдээс илгээсэн сайн туршлагыг программд байршуулж түгээн дэлгэрүүлэх;
- 4.4.10. Тайлан мэдээг нэгтгэн дүн шинжилгээ хийж Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газарт хагас, бүтэн жилээр тайланг хүргүүлэх;
- 4.4.11. Программ хангамжийн аюулгүй байдлыг эрх бүхий байгууллагаар жил бүр хянуулах;
- 4.4.12. Цахим халдлага, мэдээлэл алдагдахаас сэргийлж хамгаалах;
- 4.4.13. Программ хангамжийн ашиглалт, үйлчилгээ, цахим мэдээллийн сангийн баяжуулалт, шинэчлэлт хийх хугацааны давтамж, хөгжүүлэлтийг хариуцах зэрэг үүрэг хүлээнэ.

“ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ ХОЛБООТОЙ ТОХИОЛДЛЫГ БҮРТГЭХ” ЗУРАГЛАЛ


ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТАН

ЭТҮЧАБА-НЫ МЕНЕЖЕР

АНЭМ-ИЙН ГАЗАР

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ



Эрүүл мэндийн сайдын 2024 оны ...
сарын өдрийн ... дугаар тушаалын
гуравдугаар хавсралт.

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ, ҮНЭЛЭХ, ТАЙЛАГНАХ ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Өмчийн хэлбэр харгалзахгүй бүх эрүүл мэндийн байгууллага нь жил бүр “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөө” /цаашид Чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөө гэх/ -г боловсруулж, хэрэгжүүлнэ.

1.2. Чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөө нь эрүүл мэндийн байгууллагын чанарын удирдлагын тогтолцоог бэхжүүлэх, үйлчлүүлэгч төвтэй тусламж, үйлчилгээ үзүүлэх, эрүүл мэндийн ажилтан болон үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах, тусламж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулж, хөгжүүлэхэд чиглэнэ.

1.3. Эрүүл мэндийн хөгжлийн төв, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар нь эрүүл мэндийн байгууллагад чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөө боловсруулахад мэргэжлийн арга зүйн зөвлөгөө өгнө.

1.4. Эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөөг байгууллагын дарга, захирал батална.

1.5. Эрүүл мэндийн байгууллагын удирдлага нь үйлчлүүлэгчийн болон эрүүл мэндийн ажилтны аюулгүй байдал ноцтойгоор алдагдсан, эрсдэлт нөхцөл байдал үүссэн үед чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөөг нэн даруй хянаж, шаардлагатай тодотгол хийнэ.

1.6. Чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтийг тайлагнах, хяналт-шинжилгээ үнэлгээ хийхэд “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ыг баримтална.

Хоёр. Чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөө боловсруулах, хянах, баталгаажуулахад баримтлах зарчим, агуулга

2.1. Чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөө боловсруулахад дараах зарчмыг баримтална. Үүнд:

- 2.1.1. Эрүүл мэндийн салбарын болон тухайн байгууллагын хөгжлийн бодлого, арга хэмжээ, төлөвлөгөөтэй уялдсан байх;
- 2.1.2. Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах хүрээнд мөрдөгдөж буй хууль, эрх зүйн бичгүүдийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг тусгасан байх;
- 2.1.3. Дээд шатны байгууллага болон магадлан итгэмжлэлийн шинжээчийн багаас өгсөн санал, зөвлөмжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг тусгасан

байх;

- 2.1.4. Иргэдээс ирүүлсэн санал, гомдлыг шийдвэрлэхэд чиглэсэн байх;
- 2.1.5. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албаны орон тооны болон орон тооны бус гишүүд, эрүүл мэндийн байгууллагын тасаг, нэгжийн чанарын багийн гишүүдийн жигд оролцоог хангасан байх;
- 2.1.6. Тасаг, нэгжийн чанарын багуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан байх;
- 2.1.7. Судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх;
- 2.1.8. Нөөц бололцоонд тулгуурласан, хэрэгжихүйц байх;
- 2.1.9. Шалгуур үзүүлэлт нь хэмжихүйц, бодитой байх;
- 2.1.10. Ил, тод нээлттэй байх;

2.2. Чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөө нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна. Үүнд:

- 2.2.1. Зорилго
- 2.2.2. Зорилтууд
- 2.2.3. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа
- 2.2.4. Үр дүнгийн шалгуур үзүүлэлт
- 2.2.5. Хэрэгжүүлэх хугацаа /улирлаар/
- 2.2.6. Суурь түвшин
- 2.2.7. Хүрэх түвшин
- 2.2.8. Шаардагдах нөөц
- 2.2.9. Хэрэгжүүлэх нэгж, албан тушаалтан

2.3. Чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах зорилтуудын хүрээнд боловсруулна. Үүнд:

- 2.3.1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, удирдлагын манлайллыг бэхжүүлэх;
- 2.3.2. Эмнэл зүйн удирдамж, заавар, стандарт, эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага стандартын хэрэгжилтийг хангах;
- 2.3.3. Эрүүл мэндийн ажилтан болон үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах, тусламж, үйлчилгээний эрсдэлийг бууруулах;
- 2.3.4. Тусламж, үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх тогтолцоог бүрдүүлэх;
- 2.3.5. Тусламж, үйлчилгээний таатай орчин бүрдүүлэх, хэрэглэгчийн үнэлгээг тогтмолжуулах;
- 2.3.6. Чанар, аюулгүй байдлын шалгуур үзүүлэлт боловсруулах, хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх;
- 2.3.7. Сувилахуйн болон нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах;
- 2.3.8. Хүний нөөцийг бэхжүүлэх, чадавхжуулах;
- 2.3.9. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулах;
- 2.3.10. Шинэ технологи, сайн туршлага нэвтрүүлэх, тулгамдаж буй асуудлын хүрээнд судалгаа, шинжилгээ хийх,

2.4. Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллага нь батлагдсан төлөвлөгөөгөө Магадлан итгэмжлэлийн цахим системд жил бүрийн 1 дүгээр сарын 20-ны дотор байршуулж баталгаажуулна.

Гурав. Чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах, үнэлэх

3.1. Эрүүл мэндийн байгууллага нь чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөөний биелэлтийг хагас болон бүтэн жилээр гаргана.

3.2. Эрүүл мэндийн байгууллагын удирдлагаас томилсон баг нь чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөөний хэрэгжилтэд жилд 2 удаа хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.

3.3. Үнэлгээнд дараах зарчмыг баримтална. Үүнд:

3.3.1. Үнэлгээ нээлттэй, үнэлгээнээс гарсан тайлан, дүгнэлт ил тод байх;

3.3.2. Үнэлгээ нь шалгуур үзүүлэлт, баримт бичиг, статистик тоо, судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх;

3.3.3. Үнэлгээний тайлан дүгнэлт нь тухайн үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг тодорхойлсон, нотлогдохуйц байх;

3.3.4. Үнэлгээ хийхдээ хэрэглэгч, оролцогч талын оролцоог хангасан байх;

3.3.5. Үнэлгээний тайланд тусгагдсан мэдээллийн үнэн зөв байдлыг байгууллагын Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын (цаашид ЭМТҮЧАБА гэх) алба/баг хариуцах,

3.4. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг байгууллагын удирдлагын түвшинд хэлэлцэж, хурлаас гарсан дүгнэлт, зөвлөмжийн биелэлтийг хангуулж, хяналт тавьж ажиллана.

3.5. Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллага нь чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөөний хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор Магадлан итгэмжлэлийн цахим системд байршуулна.

3.6. Эрүүл мэндийн байгууллагын чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хөндлөнгийн байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээнд ашиглаж болно.

3.7. Чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөөний биелэлтэд өгөх үнэлгээг дараах байдлаар тооцно.

№	Үр дүн	Үнэлгээний хувь
1	Тухайн жилд тавьсан зорилт, үйл ажиллагаа бүрэн хэрэгжсэн, үр дүн нь гарсан бол	100%
2	Тухайн жилд тавьсан зорилтод бүрэн хүрээгүй боловч үйл ажиллагааг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, үр дүн гарч эхэлж байгаа бол	90%
3	Тухайн жилд тавьсан зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд өөрсдөөс хамаарах бүх арга хэмжээ авагдсан, хөрөнгө санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн бол	80%

4	Үйл ажиллагааны бэлтгэл ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд хийгдэж байгаа бол ажлын түвшнийг харгалзан	70 -60%
5	Тухайн үйл ажиллагааг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн бол ажлын түвшнийг харгалзан	50-40%
6	Үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор бэлтгэл ажил эхэлж байгаа бол ажлын түвшнийг харгалзан	30 -20%
7	Бэлтгэл ажил эхэлж байгаа бол	10%
8	Арга хэмжээ аваагүй бол	0%

3.8. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангалттай сайн (100-90%), хангалттай (89-70%), хангалтгүй (69%-аас доош) гэж дүгнэнэ.

3.9. Төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн үйл ажиллагаа тус бүрийн хэрэгжилтийн хувийг нэмж, нийт үйл ажиллагааны тоонд хувааснаар төлөвлөгөөний хэрэгжилтийн нэгдсэн хувийг гаргана.

БАТЛАВ

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН
ДАРГА/ЗАХИРАЛ

/гарын үсэг/

.....
(Эрүүл мэндийн байгууллагын нэр)

**ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР,
АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Зөвшөөрсөн:

Аймаг/нийслэлийн Эрүүл мэндийн газрын
асуудал хариуцсан нэгжийн мэргэжилтэн

/гарын үсэг/

Боловсруулсан:

Эрүүл мэндийн байгууллагын ажилтан
/албан тушаал, нэр/

/гарын үсэг/

.....ОН.....сар.....өдөр

НЭГ. ЗОРИЛГО

Эрүүл мэндийн байгууллагын чанарын удирдлагын тогтолцоог бэхжүүлэх, үйлчлүүлэгч төвтэй үйлчилгээ үзүүлэх, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах, тусламж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулж, хөгжүүлэхэд оршино.

ХОЁР. ЗОРИЛТУУД

1. Чанар аюулгүй байдлын удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг тасралтгүй хэмжиж сайжруулах
2. Чанар сайжруулах арга хэрэгсэл нэвтрүүлж, хэрэгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх
3. Хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх
4. Нотолгоонд суурилсан анагаах ухааныг хөгжүүлэх
5. Үйлчлүүлэгч төвтэй тусламж, үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх, хянах тогтолцоог олон улсын жишигт ойртуулах
6. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх, хянах тогтолцоог олон улсын жишигт ойртуулах
7. Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах, эрсдэлийг бууруулах

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх хугацаа				Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Шаардагдах нөөц	Хариуцах нэгж, албан тушаалтан
		ОН	ОН	ОН	ОН				
ЗОРИЛТ 1: Чанар аюулгүй байдлын удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг тасралтгүй хэмжиж сайжруулах									
1									
ЗОРИЛТ 2: Чанар сайжруулах арга хэрэгсэл нэвтрүүлж, хэрэгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх									
1									
ЗОРИЛТ 3: Хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх									

1										
ЗОРИЛТ 4: Нотолгоонд суурилсан анагаах ухааныг хөгжүүлэх										
1										
ЗОРИЛТ 5: Үйлчлүүлэгч төвтэй тусламж, үйлчилгээг хөгжүүлэх										
1										
ЗОРИЛТ 6: Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх, хянах тогтолцоог олон улсын жишигт ойртуулах										
1										
ЗОРИЛТ 7: Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах, эрсдэлийг бууруулах										
1										

ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

3.1 Дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээ

№	Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагааны чиглэл	Хугацаа /сар, улирал, хагас жилээр/	Хариуцах албан тушаалтан
1			
2			
3			

3.2 Хөндлөнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

№	Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлбэр	Хугацаа	Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх байгууллага
1			
2			

